# МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙН ХЯНАЛТЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны 03 сарын 22 өдөр Дугаар 11 Улаанбаатар хот

Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 26.1, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны дүрмийн 3.1.2 дахь заалт, Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны 2023 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталж, 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаатай томилон ажиллуулсугай.

2.Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн алдаа, зөрчлөөс сэргийлж, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол хийж, салбар хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороонд хугацаандаа ирүүлж байхыг салбар хороо (П.Алтангэрэл)-д даалгасугай.

3.Салбар хорооны бүрэлдэхүүнийг мэдээний санд бүртгэх, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан 2019 оны 25 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА Д.ОЮУНБИЛЭГ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙН ХЯНАЛТЫН ХОРОО УХА0578

Дашдаваа Хэрэгжилтэд хяналт
6/IV

Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны 2023 оны 03 дугаар сарын 22–ны өдрийн 11 дугаар тогтоолын хавсралт

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДЭРГЭДЭХ ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙН САЛБАР ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

| | |
|---|---|
| Ёс зүйн салбар хорооны дарга: | П.Алтангэрэл, Сургалтын менежер |
| Орлогч дарга: | Б.Бямбажав, Нян судлагч эмч |
| Нарийн бичгийн дарга: | Э.Пагмадулам, Хүний нөөцийн менежер |
| Гишүүд: | Ш.Сувд-Эрдэнэ, тархвар судлаач |
| | С.Мөнгөнбагана, Биологич |